

**ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА**





## ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨХ БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТЫН ҮР ДҮНГ ҮГҮЙСГЭХИЙГ ОРОЛДСОН НЬ

*Д.Уламбаяр\**

***Abstracts:** This article discusses two historic peculiar documents prepared by some leaders of the Central Committee of the Mongolian People's Revolutionary Party concerning the Proposal to enter the MPR into the USSR Sovereignty, which occurred shortly after the declaration of the MPR's independence by international law and its appearance on international stage as a nation state. The International legal framework of Mongolian independence founded in the Top Secret Agreement entitled, «Agreement Regarding Entry of the Soviet Union into the War against Japan» of Yalta Conference signed by Soviet Premier Joseph Stalin, U.S. President Franklin D. Roosevelt and and UK Prime Minister Winston Churchill on February 11, 1945. In Moscow, in the Sino-Soviet Treaty of Friendship and Alliance signed on 14 August 1945, China agreed to recognize Mongolian independence after its successful national referendum. The national referendum for independence was held in the MPR on 20 October 1945. It was approved by 100 percent of votes. Furthermore, during the signing of Treaty on Friendship and Mutual Assistance between the Soviet Union and the People's Republic of China on 14 February 1950, Andrey Ya. Vyshinsky, Soviet Foreign Minister, and Zhou Enlai, Premier and Foreign Minister of the PRC, in presence of Marshal Joseph Stalin, Soviet leader and Mao Zedong, Leader of the CPC, are confirmed again with exchange of notes regarding the independence of the MPR as a result of its national referendum held on 1945. The two documents of the mentioned proposal had opposing characteristics in its nature regarding the independence of the MPR.*

***Key words:** The Mongolian People's Revolutionary Party, The National Referendum*

\*\*\*

### I. Удиртгал

АНУ-ын дэд Ерөнхийлөгч Хенри А.Уоллес Алс Дорнод дахь томилолтынхоо хүрээнд 1944 оны 7 дугаар сарын эхээр БНМАУ-д хийсэн айлчлал, 1945 оны 2 дугаар сард Крымын Ялта хотноо болсон холбоотон гурван гүрний тэргүүн нарын бага хурлын үеэр байгуулагдсан “Японы эсрэг дайнд ЗХУ-ыг оролцохтой холбогдсон хэлэлцээр”-ийн 1 дүгээр болзолд: БНМАУ-ын “status quo”-г хүлээн зөвшөөрсөн, энэхүү хэлэлцээрийг удирдлага болгон 6-7 дугаар сард Кремльд

\* Доктор (Ph.D), ХИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийгэм Судлалын сургуулийн Захирал, Доктор (Ph.D)

явагдсан ЗСБНХУ, Хятадын БНУ-ын хоорондын яриа хэлэлцээ, 1945 оны 8 дугаар сарын 14-нд Москвад “ЗСБНХУ, Хятадын БНУ-ын найрамдал, холбоотны гэрээ”-нд гарын үсэг зурах үеэр солилцсон ноот бичиг зэрэг нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг баталгаажуулах бүх ард түмний санал хураалтын олон улсын эрхзүйн чухал үндэслэл болсон юм.

Улмаар 1945 оны 10 дугаар сарын 20-нд БНМАУ-д явагдсан нийт ард түмний санал асуулгын дүн тус улсын тусгаар тогтнолыг баталгаажуулж, гарсан дүнг Монголын Засгийн газар ЗХУ, Хятадын БНУ-д албан ёсоор мэдэгдсэн юм.

Удтал хүлээсний эцэст 1946 оны 1 дүгээр сарын 5-нд Чан Кайшийн Засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаагаа ноот бичгээр мэдэгдэж, тийнхүү Хятадын БНУ-ын Төв Засгийн газрын урилгаар Ерөнхий сайдын орлогч Ч.Сүрэнжав тэргүүтэй БНМАУ-ын төлөөлөгчид 1946 оны 2 дугаар сард Хятадын Төв Засгийн газар байрлаж байсан Чунцзин (Chongqing) хотноо анх удаа албан ёсоор айлчилж, мөн оны 2 дугаар сарын 13-нд БНМАУ-ын талаас Ерөнхий сайдын орлогч Ч.Сүрэнжав, Хятадын БНУ-ын талаас Гадаад явдлын сайд др. Ван Шицзе нар хэлэлцээний протоколд гарын үсэг зурж, ноот бичиг солилцсоноор БНМАУ, Хятадын БНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох болон дипломат төлөөлөгч харилцан суулгах тухай ноот бичиг солилцжээ. Яриа хэлэлцээний төгсгөлд Хятадын удирдагч Чан Кайши Монголын төлөөлөгчдийг хүлээн авч уулзахдаа: «Хятад, Монгол хоёр улс урьд [манж чин улсын түрэмгийлэлд хоёулаа ноёрхогдож байсан үед] нэг захиргаанд захирагдаж байсан юм. Японы империализмыг эсэргүүцсэн чөлөөлөх дайны үед бид хамтран байлдаж байлаа. Одоо БНМАУ өрх гэр, өмч хөрөнгөө авч үндэсний бүрэн эрхт тусгаар тогтносон улс болж байна»<sup>2</sup> гэж мэдэгдэж байсан юм

Харин Шиньжан (Синьцзян-Xinjiang), Байтаг Богдын хилийн мөргөлдөөний (Beitashan Incident 北塔山事件) хэрэг явдлаас шалтгаалан 1946-1949 оны хооронд хоёр тал элчин төлөөлөгчөө харилцан суулгаж чадаагүй байна.<sup>3</sup>

Хятадын БНУ байгуулагдсанаас хойшх 40 орчим жилд цэргийн эрхтнүүд (warlord) ч тэр, Гоминьданы удирдлагын үед ч тэр тэд эх газрын хэсэгтээ ч бүрэн эрхээ хэзээ ч хэрэгжүүлж чадаагүй атлаа “Гадаад Монгол”-ыг өөрийн нутаг дэвсгэрийн нэг хэсэг хэмээн үзэж ихээхэн том санаархалтай байсан юм (тэгээд ч Гоминьданы удирдлага тун удалгүй 4 жилийн дараа буюу 1949 онд эх газраас хөөгдсөн билээ). 1912-1949 оны хооронд эх газарт оршин тогтнож байсан Хятадын Бүгд Найрамдах Улсын түүх нь дотоодын орон нутгийн цэргийн эрхтнүүдийн хоорондын эрх мэдлийн төлөөх тэмцлийн түүх, гоминьдан, коммунистуудын хоорондын тэмцлийн түүх байсан гэж хэлж болно.

<sup>2</sup> Рэнцэнсодном С. “БНМАУ, ДИУ-ын хооронд 1945 онд хэвийн дипломат харилцаа тогтоосон тухай бяцхан дурсамж”-«Монгол элч нарын дурсамж». УБ., 1991, 92-94 дэх тал

<sup>3</sup> Ulambayar D. “The MPR’s Attempt to Join the UNs and the Position Adopted by the UK”-Trans-Continental Neighbours. Vol. 2 A History of Mongolia-UK Relations. Mongolia and Inner Asia Studies Unit, Cambridge, IIS, M.A.S. IH, M.A.S. UB.: 2014, pp. 45-60

Олон улсын эрхзүй, дипломатын практикт *status quo* гэдэгт **нэгэнт тогтсон тухайн үеийн бодит байдлыг** ойлгодог агаад харин *status quo ante bellum* гэдэгт улс орны дайны өмнөх нутаг дэвсгэр, хилийн бодит байдал, *status quo post bellum* гэдэгт дайны дараах нутаг дэвсгэр, хилийн өөрчлөгдсөн бодит байдлыг хэлдэг ажгуу.

В.Молотовын бэлтгэсэн маршал Сталины улс төрийн болзлын нэгдүгээрт: «Гадаад Монголын (Бүгд Найрамдах Монгол Ард Улс) *status quo*-г хадгална» гэж оруулсан нь дипломатын хувьд хамгийн зөв шийдэл байсан болой. “Одоогийн бодит байдал” гэдэг нь 1924 оны 5 дугаар сарын 31-ний хэлэлцээрийн бодит байдал биш, харин 1924 оны 11 дүгээр сарын 26-нд Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсыг тунхагласан Монгол Улсын Хятадын БНУ-аас огт хамааралгүй оршсоор ирсэн тэрхүү бодит байдал байсан нь тодорхой юм. Тиймээс Ялтын хэлэлцээрийн нэгдүгээр болзолд хашилганд “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж онцлон оруулсан тодотголоос тов тодорхой харж болно.

1945 оны 2 дугаар сард Ялтад болсон холбоотон гурван гүрний бага хурлын үеэр байгуулагдсан хэлэлцээрт АНУ шийдвэрлэгч оролцогч болж, хэлэлцээрт тусгагдсан «БНМАУ-ын *status quo*»-г хадгалах тухай заалт БНМАУ-ын олон улсын эрхзүйн хоёрдмол ойлголтыг нэг мөр шийдвэрлээд зогсохгүй, БНМАУ олон улсын эрхзүйн субъект мөнийг хүлээн зөвшөөрсөн анхны олон улсын эрхзүйн нэн чухал баримт бичгийн үндэс болж, энэ нь Зөвлөлт-Дундадын найрамдал, холбоотны гэрээгээр БНМАУ нь Хятадаас ямар ч хамааралгүй, тусгаар оршин тогтнох, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх замыг нээж, 1945 оны тусгаар тогтнолын асуудлаарх бүх ард түмний санал хураалтын дүн түүнийг баталгаажуулжээ.

1949 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ байгуулагдсаныг зарлан тунхаглаж, Ардын Төв Засгийн газрыг “Хятадын бүх ард түмнийг төлөөлөх цорын ганц хууль ёсны Засгийн газар мөн” гэж мэдэгдэв. Улмаар Ардын Төв Засгийн газар “тэгш эрх, харилцан ашигтай байх, бие биеийн газар нутгийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхийн зарчмуудыг дагаж мөрдөхөө илэрхийлсэн гадаадын аль ч орны Засгийн газартай дипломат харилцаа тогтооход бэлэн байгаа” тухайгаа зарлан тунхаглажээ. Энэ уриалгыг анх түрүүн ЗХУ 1949 оны 10 дугаар сарын 2-нд хүлээн авснаар хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтов. БНХАУ-ын ГЯЯ-ны ноотод: “Өнөөдөр ЗХУ БНХАУ-ыг хүлээн зөвшөөрсөн анхны нөхөрсөг их гүрэн болсон явдалд Хятадын Засгийн газар, ард түмэн хязгааргүй баярлаж байна” гэжээ. Удалгүй ЗХУ-ын элчин сайд хошууч генерал, цэргийн тагнуулч Н.В.Рощин Бээжинд, БНХАУ-ын элчин сайд Ван Цзясян (Wang Jia-xiang 1906-74) Москвад томилогдон ирж ажилдаа оржээ.<sup>4</sup>

1949 оны 10 дугаар сарын 1-нд шинээр ардын ардчилсан БНХАУ байгуулагдахад хоёр улсын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Х.Чойбалсан, Жоу Энълай нар ноот бичиг харилцан солилцсоноор 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа

<sup>4</sup> Борисов О.Б, Колосков Б.Т. Советско-Китайские отношения 1945-1977. М., 1977, с. 37

тогтоов. БНМАУ-ын Засгийн газрын даалгавраар тус улсаас ЗСБНХУ-д суугаа элчин сайд Н.Ядамжав Гоминьданы Засгийн газрыг төлөөлөн Москвад суугаа элчин сайд Фу Бинчжанд 1949 оны 10 дугаар сарын 6-нд мэдэгдэхдээ: «Хятадын ард түмний хүсэл зоригоор БНХАУ-ыг тунхаглаад БНХАУ-ын засгийн бүх эрхийг барих Ардын төв Засгийн газрыг байгуулсан учир улсынхаа дотор үнэндээ ямар ч эрх мэдэлгүй болсон бөгөөд хойшид Хятадын ард түмнийг төлөөлж чадахаа больсон Кантоны Засгийн газартай дипломат харилцаагаа таслахаар БНМАУ-ын Засгийн газраас шийдвэрлэв» гэжээ.<sup>5</sup>

1950 оны 2 дугаар сарын 14-нд ЗСБНХУ, БНХАУ-ын найрамдал, харилцан туслалцах гэрээ болон бусад хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах ёслол Кремльд болж, Зөвлөлтийн талаас ГЯЯ-ны сайд А.Я.Вышинский, Хятадын талаас Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Жоу Энълай нар гарын үсэг зурж, Зөвлөлтийн удирдагч И.В.Сталин, БНХАУ-ын удирдагч Мао Цзедун нар байлцжээ. Үүнтэй нэгэн зэрэг А.Я.Вышинский, Жоу Энълай нар хоёр улсын Засгийн газрыг төлөөлөн **“БНМАУ-ын тусгаар тогтносон байдал нь 1945 оны санал хураалтын үр дүн ба БНХАУ-аас түүнтэй дипломат харилцаа тогтоосон явдлын дүнд бүрэн хангагдсан гэж батлан тэмдэглэж байна”**<sup>6</sup> гэсэн ноот бичиг харилцан солилцсон нэн чухал ач холбогдолтой байв.

## II. БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах санал тавьсан нь

БНМАУ-ын тусгаар тогтнол олон улсын эрхзүйгээр хөлбөргүй баталгаажиж, олон улсын тавцанд *nation state*-ийн хувиар гарч ирээд тун удаагүй байсан цаг дор МАХН-ын ТХ-ны удирдах зарим зүтгэлтнүүд 1950 оны эхээр БНМАУ-ыг ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд оруулах санал тавьж байсан тухай түүхийн ноцтой баримт өөрчлөн байгуулалтын төгсгөл үед ил гарч ирсэн билээ.<sup>7</sup>

Москвагийн улсын их сургуулийн аспирант Д.Төмөр-Очир, Л.Цэнд, Намын дээд сургуулийн төгсөх ангийн сонсогч Цагаанлхамын Дүгэрсүрэн, Ю.Цэдэнбалын туслах, хожим Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын даргаар олон жил ажилласан Б.Бадарч, Намын дээд сургуулийн багш С.Авирмэд, Г.Галбадрах зэрэг хүмүүс албан ёсоор анх удаа БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудлыг есөн зүйл үндэслэлээр боловсруулж, 1950 оны 7 дугаар сарын 3-нд «Хайрт жолоодогч, багш маршал Чойбалсан, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нөхөр Цэдэнбал нар Танаа» хэмээн саналаа тавьжээ. Тэд саналаа улам лавшруулан боловсруулж төд удалгүй асуудлыг «Маш нууц» гэсэн нэрээр дахин тавьж байжээ. Гурван хувь гэж тэмдэглэсэн уул бичгийн эх ноорог 1965 онд Д.Төмөр-Очирын<sup>8</sup>

<sup>5</sup> БНМАУ-ын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1-р боть. УБ., 1964, 79 дахь тал

<sup>6</sup> Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. XX зууны сүүлийн хагаст. Дэд боть. УБ., 2020, 264-265 дахь тал

<sup>7</sup> “БНМАУ-ын ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудал тавьсан нь” Үнэн сонин. 1990.07.30 №178

“БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудлыг дахин тавьсан нь” Үнэн сонин. 1990.08.07 №185

<sup>8</sup> Төмөр-Очир, Дарамын (1921-1985) Төв аймгийн Лүн суманд төрсөн. 1938-1941 онд ЗХУ-д Дорно дахины дээд сургууль (КУТВ), 1945-1950 онд Москвагийн улсын их сургуулийг философич мэргэжлээр дүүргэсэн.

гэрээс хурааж авсан зарим баримт бичгийн дотор орж, улмаар Намын Төв архивт орж хадгалагдан үлдсэн байна.

Дурдсан бичигт: «**Нэгдүгээр асуудал:** БНМАУ МАХН-ын удирдлагын дор, их Зөвлөлт Социалист Улсын сэтгэл харамгүй их тусламжийг хүлээж ирсний ачаар намын X их хурлын үест капиталист бус хөгжлийн зам дээр эргэлтгүй гарч, одоо тэр замаар улмаар хөгжиж байна. Үүнээс үндэслэн одоо манай улс социализмыг байгуулах явдалд шууд шилжин орох цаг болсон гэж үзэж болох уу? **Хоёрдугаар асуудал:** Манай улс ЗХУ-ын бүрдэлдэхүүнд багталцан оролгүйгээр капиталист бус замаар амжилттай хөгжиж ирсэнтэйгээ адил социалист нийгмийг бүрэн төгс байгуулж чадах эсэх? Социализм манай оронд бүрмөсөн ялах явдал Зөвлөлтийн Холбоонд багталцан орох явдалтай уялдсан байх уу? Үгүй юу? Хэрвээ уялдсан байвал СССР-тэй манай улсын нэгдэх явдалд саад тотгор болж байгаа гадаад ба дотоодын ямар учир шалтгаан байгаа вэ? **Гуравдугаар асуудал:** Нийгмийн хөгжлийн хуулийн үүднээс үзэхэд социализмыг байгуулах явдалд зайлшгүй аж үйлдвэрийг хөгжүүлэн, үйлдвэрчний тоог олшруулж, ажилчин ангийн диктатурыг батжуулдаг байна. Зөвлөлтийн урьд хоцрогдмол байсан республикүүдийн социализмыг байгуулсан туршлага ба ардын ардчилсан орнуудын одоогийн практик нь энэ хөдөлбөргүй хуулийг батлан нотолж байна. Манай улсын одоогийн туршлагыг үзвэл бидний санахад, энэ талаар гойд онцлог байна. Манай орны энэ онцгой байдлыг юугаар тайлбарлах вэ? **Дөрөвдүгээр асуудал:** Зөвлөлт улсын аж үйлдвэр нь тусгаар тогтносон манай улсад социализмыг байгуулах явдлын материаллаг суурь нь болох уу? Хэрвээ болох аваас манай хоёр улсын хоорондын эдийн засаг, соёлын харилцаа ба гадаад худалдааны талаар ямар нэгэн гойдын шинэчлэлт гарах уу? **Тавдугаар асуудал:** Манай улсын одоогийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй нь цаашид социализмыг байгуулахад материаллаг суурь болж чадах уу? Нөхөр Сталины зөвлөснийг удирдлага болгон X их хурлаас тус улсын малын тоог ойрын ирээдүйд 200 саяд хүргэх зорилгыг тавьсан билээ. Намын XI их хурлаас ойрын 2-3 таван жилийн дотор малын тоог 3-4 дахин нэмэгдүүлэх хэрэгтэй гэжээ. Хэрвээ энэ нь их хурлын үед малын тоог 20 орчим сая байсан гэж бодвол 60-80 сая тоонд хүрмээр бидэнд ойлгогдож байна. Гэтэл Намын XI их хурал ба Төв Хорооны 1 дүгээр сарын бүгд хурлын шийдвэрүүд нь X их хурлаар тавьсан малын тоо толгойг 200 саяд хүргэх тухай зорилгын үргэлжлэл буюу тодорхойлол гэж ойлгож болох уу? Хэрвээ тийм бол ямар арга замаар тэр зорилгод хүрч болох вэ? Мал аж ахуй дээр гарах үндсэн шинэчлэлт,

---

1950-1953 онд ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны академийн аспирантурт суралцаж, “Монгол Улсын капиталист бус хөгжлийн замын судалгаа”-аар философийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. 1961 онд ШУА-ийг байгуулахад академич цол хүртсэн. 1941-1944 онд Намын төв хорооны нарийн бичгийн дарга нарын туслах, Шинэ хүчний дээд сургуульд философийн багш, тэнхимийн эрхлэгч, МАХН-ын ТХ-ны дэргэдэх Намын Түүхийн институтийн захирал, МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн даргаар сонгогдон ажиллаж байсан юм. 1962 оны 9 дүгээр сард хуралдсан МАХН-ын ТХ-ны III бүгд хурлаас Д.Төмөр-Очирыг Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэж, Хэнтий аймагт хөшөө босгуулж, марк хийлгэснийхээ төлөө үндэсэрхэх үзэл гаргасан, “намын эсрэг ажил явууллага” үйлдсэн хэмээн бүх ажил, албан тушаалаас нь огцруулж, 23 жил үргэлжилсэн цөллөгө, хавчилт, хэлмэгдүүлэлт эхэлжээ. 1985 онд бусдын гарт онц хэрцгийгээр амь насаа алдсан.

хувиралт нь малын тоог дээр дурдсан тоонд хүргэхийн тулд гарах уу? Эсхүл мөн тоонд хүрсэн хойно, түүгээр суурь болгон хийгдэх үү? **Зургадугаар асуудал:** Ардын аж ахуйтанд малаа өсгөх төлөвлөгөө тогтоосон явдал нь намын их ба бүгд хурлаас заасан зорилгыг биелүүлэхэд шийдвэрлэх үндсэн арга зам болж чадах уу? Ер нь манай улсын хувийн өмчит ардын аж ахуйтнуудыг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх бололцоотой болгосон эдийн засгийн талын нөхцөлүүд юу вэ? **Долдугаар асуудал:** Тус улсын эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй нь ардын хувийн өмчинд байгаа цагт улсын гарт байгаа аж үйлдвэр, тээвэр, банк, гадаад худалдаа, сангийн аж ахуй, хадлангийн станцууд, бэлчээр газар ба түүний баялаг бол эдийн засагт командлах салбар болж чадах уу? Эсхүл улс ардын аж ахуйн эдгээр элементүүд нь ардын аж ахуйд ноёрхох салбар болж байгаа хувийн өмчит нүүдлийн мал аж ахуйд түшиглэн захирагдаж байх уу? **Наймдугаар асуудал:** Манай улсын дотор хувийн аж ахуйтнуудыг хамтралжуулах явдлын нөхцөлүүд нь одоо гүйцэд бүрэлдсэн гэж үзэж болох уу? Хэрвээ бүрэлдээгүй бол чухам ямар нөхцөл нь дутагдаж байна вэ? Манай орны нөхцөл байдалд ардын өмчит аж ахуйтнуудыг социализмын байгуулалд өргөнөөр татан оролцуулахын шийдвэрлэх гол арга замууд ямар байх вэ? Зөвлөлт Улсад нийтээр хамтралжуулсны туршлагаар хөдөө аж ахуйн артель орох уу? Эсхүл одоогийн байгаа ардын энгийн нэгдэл нь хөдөө аж ахуйн артельд шилжихийг заавал дамжих шат буюу хэлбэр болох уу? **Есдүгээр асуудал:** Ардын аж ахуйн хувийн сонирхол санаачилгыг дээшлүүлэхэд чиглүүлэн нам, засгаас авч байгаа урамшуулах арга хэмжээнүүд (олон төрлийн хөнгөлөлт, тусламж, шагнал) нь тэдгээрийг хамтралжуулах явдалд бэлтгэж байгаа арга хэмжээнүүд гэж үзэх үү? Эсхүл, эдгээр арга хэмжээнүүд нь жижиг бүрзийлэг (буржуазный буюу хөрөнгөтөн Д.У) шинжтэй ардын аж ахуйтны хувийн өмчөө хамгаалах ба бэхжүүлэх эрмэлзлэл, хандлагыг батжуулахад хүргэх тал байна уу? Үндсэн бодлогын эдгээр гол асуудлуудыг зөвөөр шийдвэрлэх нь энэ талаар ямагт маргалдаантай байдаг намын идэвхтэн, кадрууд ба өргөн олон сэхээтний сэнхрэн ухамсарлах ба хүмүүжих явдалд туйлын их ач холбогдолтой байна. Учир иймд эл асуудлыг та бүхний өмнө тавьж ойрын цагт хангалттай хариуг авахыг гүнээ итгэнэ!» гэжээ.

### III. Тусгаар тогтнолын төлөөх бүх ард түмний санал хураалтын дүнг үгүйсгэсэн дүгнэлт

Баримт бичгийн дотор тавьсан есөн асуудалд Чойбалсан, Цэдэнбал нарын хэн нь ч бичгээр хариу өгсөн баримт одоогоор гарч ирээгүй байна. *Харин асуудал тавьсан намын удирдах зүтгэлтнүүд “Маш нууц” гэсэн уул асуудлууддаа өөрсдөө оршил, 8 зүйлээр ноцтой хариу өгч, улмаар БНМАУ-ыг ЗХУ-д нэгтгэн нийлүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн хоёр дахь албан бичгийг бичиж Чойбалсан, Цэдэнбал нарт өгчээ.*<sup>9</sup> Уул бичгийн хуулбар эх Намын Төв архивт хадгалагдан үлджээ.

<sup>9</sup> “БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудлыг дахин тавьсан нь” Үнэн сонин. 1990.08.07 №185



Есөн зүйл саналын бичигтэй өөрсдөө хариултыг нь өгсөн хоёр дахь баримт бичигт: “Хэрэв манай улс ялсан пролетарийн улс гүрний тусламжийг авснаар хөрөнгөтний бус нийгэм журмын замаар хөгжих суурь үндсийг тавьж чадсан ахул, цаашид СССР-ын холбоонд оролгүй мөн энэчлэн тусгаар тогтносон бүгд найрамдах улс хэвээр явж социалист нийгмийг бүрэн төгс байгуулж чадахгүй, хэрхэх билээ? гэж бид өөрсдөөсөө асуугаад үзэхүл хэдий үндэсний бардам сэтгэл зориг дүүрэн байвч өөрийн орны эдийн засаг, соёл боловсролын эдүгээгийн байдал ба цаашид хөгжих нөхцөл бололцоог харгалзан бодоход ЗХУ-ын бүрэлдэхүүнд багталцан ороогүй цагт манай оронд социализм бүрмөсөн ялах явдал өнө удаан хугацаа шаардагдах, маш хэцүү бэрх юм шиг санагдаж байна. Нэгэнт манай улс Европ дахь ардчилсан улсуудаас онцлог замаар социализмд орох гэж яваа орон болох учраас бид өөрийн улсад социализмыг байгуулахдаа тэдгээр орны туршлагыг хуулбарлан хэрэглэх явдалгүй, харин манай орны тодорхой түүхт онцлог байдлыг харгалзах нь чухал юм. Үүнд манай оронтой ижил төсөөтэй байдалд урьд оршиж байгаад хөрөнгөтний нийгмийн байгууллагыг алгасаж, улмаар Зөвлөлтийн холбоонд багталцсаны ачаар капитализмын шатыг алгасаж социализмыг байгуулж амжсан Дундад Азийн зөвлөлт социалист республикуудын туршлагыг дагаж мөрдвөөс зүй зохистой мэт санагдана... Бидний санахад ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтсан хоцрогдонгүй үндэстний замнасан зам бол социализмд шилжин дэвших ёстой хураангуй дөхөм зам мөн бөгөөд хөрөнгөтний нийгмийн хөгжлийн шатыг бүрэн алгасаж чаджээ... Монгол улсад социалист нийгмийг бүрэн байгуулахын тулд материаллаг техникийн хүчирхэг баазтай болох ёстой. Тийм баазыг бидэнд ганц Зөвлөлтийн аж үйлдвэр тавьж өгөх юм. Гэхдээ бид ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтан орсон тухайд сая тийм баазтай болж чадна. Нэгэнт учир ийм болоход манай улс өөрийн амьдрал ба хөгжлийн эрэлт шаардлагаар эрт орой хэзээ боловч тэрхүү холбоонд багталцан орох нь гарцаагүй болж ирнэ. Ийм сануулга манай өмнө тулгарч буй хэмээн бид санах болов. Хэдий даруй түргэн тусмаа манай хөгжил төдийчинээ түргэсэн, манай эх орон гэрэлтэн харагдах социализмын оройд хүрнэ. МАА-гаар социализмын байгуулалтын материаллаг суурь болгоно гэж сэтгэдэг манай зарим нөхөд эндүүрч буй мэт санагдана. Учир нь гэвэл манай улс Зөвлөлтийн Холбооноос гадуур тусгаар тогтнон оршиж байгаа цагт чингэж батлах ер үндэсгүй бөгөөд буруу биз... Хоцрогдмол техниктэй ардын хувийн аж ахуйнуудыг социализмын замд шилжүүлэн оруулбаас сая хатуу ширүүн зуд, ган гачигаас малын тоо хорогддог явдлыг зогсоож, Монголын МАА-н хөгжлийг хөдөлбөргүй байнга тогтвортой болгож чадна. Гэтэл МАА-г хөгжүүлэх талаар энэхүү эрс цочмог эргэлтийг хийхийн тулд ЗХУ-ын зүгээс хүчтэй тусламж зайлшгүй шаардагдана... Манай улс зөвлөлт республикуудын гэр бүлд багталгүйгээр тусгаар тогтносоор байвал манай боловсон хүчний нилээд хувь нь ажилд шилжих ба улсын төсөв зардлын үлэмжхэн хэсэг нь гадаад улсуудтай харилцах хэрэгцээг хангах явдалд үр багатайгаар зарцуулагдахад хүргэнэ. Манай их сургууль ба намын шинэ хүчний дээд сургууль боловсронгуй багшлах хүчнээр дутагдалтай тул багш нарын орон тоог мөнхүү сургуулийг төгсгөсөн залуучуудаар

бөглөж ажиллуулах нь манай үндэсний мэргэжилтнийг бэлтгэх ажлын чанарыг ихэд сулруулахад хүрч байна. Үүнээс гадна Хятад улсад хувьсгал ялж, ардын засаг тогтсоны ачаар манай улсын тусгаар тогтносон байдал бүрэн дүүрэн багтай болсон явдал нь манай улсаас Зөвлөлтийн холбоонд орох асуудлыг тавихад уудам чөлөөг тавьж өгсөн хэрэг даруй мөн хэмээн бид үзнэ. Бид нар төлөвлөсөн асуудлуудын талаар өөрсдийн саналыг гаргахдаа бүх зүйлсийг нэгэн гол зүйлд захируулж буй. Учир нь манай хөгжлийн бүх үндсэн асуудлууд нь Зөвлөлт Улсын Холбоонд багтан орсон тухайд сая бүрэн шийдвэрлэгдэх мэт санагдана” гэжээ.<sup>10</sup>

Хамгийн анхаарал татаж буюу асуудал нь тэдгээрийг анх хэний санаачилгаар үйлдэж, тэнд байгаа гол санаа болох БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах гэсэн зорилгыг хэн хэн голлон баримталж байсан, яагаад, хэдийд уул асуудал намжиж зогссон зэргийн талаар албан ёсны баримт бичиг, холбогдох хүмүүсийн дуртгал яриа зэргээс тэмдэглэж болохоор байгаа юм.

1990 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлаар МАХН-ын онц их хурлаас байгуулагдсан комиссын дарга Б.Сумъяагийн тавьсан «Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд өгөх улс төрийн дүгнэлт» илтгэлд тэмдэглэхдээ: Цэдэнбалыг “...тэр ч байтугай 40-өөд оны сүүлчээр хэн ч шаардаагүй байхад Б.Жамбалдорж, Д.Төмөр-Очир, Ц.Дүгэрсүрэн нартай хамтран БНМАУ-ыг ЗХУ-д нэгтгэн нийлүүлэх асуудал боловсруулан хөөцөлдөж байсан...”<sup>11</sup> гэжээ.

МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга, нэг, хоёрдугаар нарийн бичгийн даргаар 1939-1959 оны эх үе хүртэл ажиллаж байсан Дашийн Дамба агсан дуртгалдаа: «...Нэг өдөр Цэдэнбалын өрөөнд цуглаад байтал Чойбалсан маш их ууртай орж ирээд Төмөр-Очир (аспирантурт сурч байхдаа), хар Дүгэрсүрэн нар Монголыг ЗХУ-тай нэгтгэе гэж ярьдаг гэнэ. Энэ бол буруу асуудал. Монгол бол дөрвөн гүрний хэлэлцээрээр тусгаар тогтносон улс гэхэд, Цэдэнбал Монгол ЗХУ-д нэгдсэнээр монголын үндэс, угсаа нь балраад үгүй болчихгүй хэвээрээ л байна шүү дээ гэхэд, Чойбалсан үндэстэн гэж байна, үндэстний улс гэж байна. Хэдэн зуун жил Монгол Улс тусгаар тогтноод ирсэн юм. Битгий дураараа аашлаад бай гэж уурлаж байсан. Үүний дараа Сталин нас барж (Х.Чойбалсан 1952 оны 1 дүгээр сарын 26-нд, И.В.Сталин 1953 оны 3 дугаар сарын 5-нд нас барсан Д.У) их гашуудал болов. Энэ үед АИХ-ын чуулган болж байв. Улс Төрийн Товчооны хурал дээр Сталин нас барсанд бүх нийтээр гашуудлын ажлыг өргөн зохиох тухай ярилцахад Улс Төрийн Товчооны орлогч гишүүн, Улсын прокурор Жамбалдорж уйлж байгаад манайх шиг жижиг улс тусгаар тогтнож байгаад хэрэггүй. ЗХУ-ын нэг хамсаатан болъё гэсэн санал гаргахад Бумцэндээс бусад нь зөвшөөрч, тогтоол гаргах болж төслийг Жамбалдорж Улс Төрийн Товчооны орлогч гишүүн Дотоод яамны сайд Цэдэв, Н.Лхамсүрэн нар боловсруулах болсон. Бумцэнд их дурамжханаар ингэж болох

<sup>10</sup> “БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудлыг дахин тавьсан нь” Үнэн сонин. 1990.08.07 №185

<sup>11</sup> МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлын сонгол мэдээ. Үнэн сонин. 1990.06.30. №155 (17685)

юм уу? Сайн бод! Одоо ингээд байхад юу нь болохгүй байна гэж байв» гэжээ.<sup>12</sup>

«Тогтоолын төслөө бэлдчихээд байтал Цэдэнбал ЗХУ руу Сталиныг оршуулах ёслолд оролцох болсон. Цэдэнбал намайг дуудаж, дээрх асуудлаа тэгсхийгээд зогсооно байгаа, тэр тогтоолыг гаргуулахгүй байх нь зүйтэй байх гэж хэлсэн. Тэгэхэд нь би Цэдэнбалыг зөвлөлтийн нөхөдтэй яриад хэрэггүй гэсэн юм байна гэж бодсон...» гэж Д.Дамба үргэлжлүүлэн дурссан байна.

ГЯЯ-ны сайд, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Нямтайширын Лхамсүрэн эдгээр бичгүүдийг хэн хэн, хэдийд, хэрхэн бичиж боловсруулсан талаар нэлээд тодорхой ярьж тэмдэглүүлсэн байдаг. Тэрбээр ярихдаа: «...1950 оны үеэс Цэдэнбалын санаачилга, хатгалгаар ЗХУ-д дагаар орох гэдэг яриа дэлгэрч эхэлсэн. Тэр нь Москвагийн намын сургуульд суралцагсад, Намын Төв Хороо, Засгийн газарт ажиллаж байсан хүмүүсийн дунд гарсан юм. Энэ нь Цэдэнбалын оролдлого байсан...Ингээд 1950 оны зун Москвад сурч байсан аспирант Төмөр-Очир, Цэнд, Намын дээд сургууль төгсөх гэж байсан Цагаанлхамын Дүгэрсүрэн, Цэдэнбалын туслах, хожим Хэрэг эрхлэх газрын дарга байсан Бадарч, мөн аспирант Сүрэнжав гуайн дүү Галбадрах, Намын дээд сургуулийн багш Авирмэд эд нар Москва, Улаанбаатарын хооронд нэлээд идэвхтэй бичиг захидлаар харилцаагийг Чойбалсан надад хэлж байсан. Тэгээд Авирмэдэд даалгавар өгч Намын дээд сургуулиас 6 ханатай гэр Сонгины аманд аваачиж бариулж идээ ундаа, хоол сэлт бэлтгэсэн. Энэ тухай Авирмэд бичихдээ, мөн тэр газар гэр бариулж, их сургуулийн нэгэн орос багштай хамт амарч байтал бусад таван нөхөд очиж, хамт амрах зуур ЗХУ-д нэгдвэл яасан юм бэ гэж ярилцаад Чойбалсан, Цэдэнбал нарт асуудал тавьсан захидал бичсэн юм гэсэн санааг хэлжээ. Тэгээд БНМАУ-ын Ерөнхий сайд Чойбалсан, Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Цэдэнбалын нэр дээр Монголыг СССР-т дагаар оруулья гэсэн утгатай өргөдөл бичиг бичжээ. Нэлээд олон хуудас... их том юм бичсэн. Найруулгын чадал их сайн. Нотолгоо нь ч яггүй. Хэдэн хоног бичээд түүнийгээ аваад Баянголд Цэдэнбалын дэргэд байсан Бадарчийнд авч очсон. Түүнийгээ уншсан. Цэдэнбал сайшааж, бас тэндээ найрласан. Тэр өргөдлийг нь Цэдэнбал авч редакторлаад Чойбалсанд авчирч өгсөн...» гэжээ. Н. Лхамсүрэнгийн ярианд Цэдэнбалын явуулгаар хэлмэгдсний хувьд түүнийг голлон буруутгах санаагаа цухалзуулж байгаа хэдий боловч үндсэндээ санаагаа гаргасан ажээ.

Эдгээр баримтуудаас үзвэл дээрх хүмүүс Монгол Улсыг ЗХУ-тай нэгтгэх асуудлыг тавьсан хоёр бичгийг үйлдэж, Цэдэнбал түүнийг боловсруулахад оролцон хөөцөлдөж байсан бололтой байдаг. Хамгийн гол зүйл гэвэл хэдийгээр Монголыг ЗХУ-д нэгтгэн нийлүүлэх асуудлыг сэдэж, хөөцөлдсөн хэсэг хүмүүс байсан нь үнэн боловч тэдний хүсэл зоригоор БНМАУ тусгаар тогтнолоо алдчихаагүй өөр нэгэн няцаагдашгүй үнэн буй. Нөгөө талаар ЗХУ Монгол Улсыг өөртөө нэгтгэн авах гэсэн бодлого зорилго тавиагүй, тийм бодлого баримтлах нөхцөл боломж ч байгаагүй юм.

<sup>12</sup> “БНМАУ-ын ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудал тавьсан нь” Үнэн сонин. 1990.07.30 №178

ЗСБНХУ Хятадын бодлоготой холбоотойгоор Монголыг өөртөө шууд нэгтгэх бодлого, сонирхол байгаагүй гэдгийг юуны өмнө тэмдэглэх ёстой. Түүхийн тодорхой баримтаас дурдвал, Зөвлөлт Оросын Засгийн газар бүр 1919 оны намар Монголын ард түмэнд хандаж гаргасан Тунхаг бичигт: “Үүнээс хойш Монгол Улс бол өөртөө эрхт тусгаар нэгэн орон мөн... Засгийн бүрэн эрх цөм Монголын хязгаар дотор гагцхүү монгол өөрөө эрхлэн мэдвэл зохино. Монголын дотоод хэрэгт ямар ч гадаадын хүн нар оролцох эрхгүй. Монгол Улс тусгаар тогтносон орны ёсоор Бээжин, Петроград хоёроос асуулгүй аливаа олон улс лугаа шууд харилцан нэвтрэлцэх эрхтэй болсон явдлыг манай Зөвлөлт Засгийн газраас Монгол үндэсний улсад чухам мэдэгдэн тунхаглав” гэжээ. Урд өмнө аль нэг улс гүрэн тухайн үеийн буурай Монголд ингэж хандаж байгаагүй билээ.

1921 оны 11 дүгээр сард Зөвлөлт Орос улсын Засгийн газар Ардын Засгийн газрыг хүлээн зөвшөөрч “Монгол-Зөвлөлт Оросын хооронд найрамдлын барилдлага байгуулах Гэрээ”-нд Москва хотноо гарын үсэг зурснаар хоёр улсын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтсон юм. Улмаар 1922 оны 6 дугаар сард Москвад Ардын эрхт Монгол Улсын Бүрэн эрх барих элчин Төлөөлөгчийн газар нээгдэж анхны элчин төлөөлөгч түшээ гүн Ж.Даваа бээр Бүх Оросын Төвийн гүйцэтгэх Хорооны дарга М.И.Калининд ИЖБ-гээ барьж ажилдаа орж байсан ахул мөнхүү 7 дугаар сард нь Зөвлөлт Орос улсын Бүрэн эрх барих элчин төлөөлөгч Ю.Любарский Ерөнхий сайд Жалханз хутагт С.Дамдинбазарт ИЖБ-ээ барьж ажилдаа орж байсан юм.

Гэвч Зөвлөлт Засгийн газар 400 сая хүн амтай Дундад улсыг асар их хувьсгалжуулах, Хятадын БНУ-тай дипломат харилцаа тогтоох, Дорнод Хятадын төмөр замын асуудлаарх өөрийн бүрэн эрхээ сэргээн хэрэгжүүлэх зэрэг шаардлагын улмаас Бээжингийн эрх баригчдад буулт хийж, 1924 оны 5 дугаар сарын 31-нд Бээжин хотноо байгуулсан «ЗСБНХУ ба Хятадын БНУ-ын хоорондын асуудлыг зохицуулах Ерөнхий зарчмын тухай хэлэлцээр»-ийн 5 дугаар зүйлд «ЗСБНХУ нь Гадаад Монгол нь Хятадын Бүгд Найрамдах Улсын бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрч, тэнд Хятадын суверенитетийг хүндэтгэнэ» гэж заасан байна. Мөн дурдсан хэлэлцээрт тусгай бага хурал зарлан хуралдуулж, түүгээр хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасны дагуу Монголын асуудлаар хэлэлцээ явуулж, Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргах тухай заасан юм. Алс Дорнодын олон улсын байдал, Хятад дахь иргэний дайны улмаас бага хурлыг зохион байгуулж чадаагүй билээ. Харин *Нэгд.* Дурдсан гэрээгээр Зөвлөлт Оросоос Гадаад Монголтой байгуулсан тусгаар тогтнолын 1921 оны гэрээг хүчингүй болгох тухай огт дурдаагүй, *хоёрт.* Гадаад Монголоос Оросын цэргийг гаргах хугацааг товлоогүй зэрэг байсан юм.

Гэхдээ 1924 оны Бээжингийн хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн заалтын ноцтой нь 1919 оны Зөвлөлт Засгийн газрын Тунхаглал, 1921 оны Монгол-Зөвлөлтийн найрамдлын Гэрээний заалтад илт харшилсан үйлдэл байсан бөгөөд Москвагийн байр суурь автономоос Хятадын суверенитетийг хүлээн зөвшөөрөх хүртэл өөрчлөгдсөн нь Хаант Оросын бодлогоос ч доошилсон хэрэг байв. Энэ нь Хятадаар

өөрийгөө зөвшөөрүүлж харилцаагаа зохицуулахын тулд Зөвлөлт Засгийн «арга буюу» хийсэн буулт гэж тухайн үед ойлгогдож байсан боловч жинхэнэ санаа бодлого нь нэлээд гүнзгий байсныг цаашдын үйл явдал нотолсон билээ.

Гэвч 1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар Их хурал Монгол Улсыг Бүрэн эрхт Бүгд Найрамдах Ард Улс хэмээн тунхаглан зарлаж, Улсын анхдугаар Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан явдал дотоодод болон гадаад дахинтай бие даан харилцах бүрэн эрх бүхий олон улсын эрх зүйн субъект мөнийг дэлхий дахинд нотлон харуулсан юм.

1925 оны 3 дугаар сард Тбилиси хотноо хуралдсан ЗСБНХУ-ын Төвийн Гүйцэтгэх Хорооны 3 дугаар чуулганд тавьсан илтгэлдээ Зөвлөлтийн дипломат албаны тэргүүн Г.В.Чичерин ЗХУ Монголтой улам нягт ойртож байна. Саяхан Монгол Улсын анхдугаар Их хурал хуралдаж, Үндсэн хуулиа баталж, Бүгд найрамдах засаг тунхаглаж, ЗХУ-тай найрамдлаа гуйвалтгүй бэхжүүлж, түүний интернационалч тусламжтайгаар үндэсний тусгаар тогтнолыг бататгах, улс орноо хөгжүүлэх шийдвэр гаргасныг талархан тэмдэглээд, Зөвлөлтийн ард түмний тусламжтайгаар эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон Монголчууд ЗХУ-тай улам ойртож, үүрд баг зузаан холбоотой байх нь хамгийн чухал<sup>13</sup> гэж хоёр нүүрт бодлогоо тайлбарлаж байсан юм.

ЗХУ 1921 оны Монгол Улстай байгуулсан гэрээг «ЗСБНХОУ-аас гадаад улсуудтай байгуулсан хүчин төгөлдөр гэрээ, хэлэлцээр, конвенцүүдийн эмхтгэл»-ийн 1924 оны дугаар 1-т нийтэлжээ.<sup>14</sup> Цаашилбал Францид сууж байсан ЗХУ-ын элчин сайд Л.Б.Красин 1925 оны 1 дүгээр сард «БНМАУ бол тусгаар тогтносон улс мөн» гэж албан ёсоор мэдэгдсэнийг Парисын өдөр тутмын «*Le Temps*» сонин 1 дүгээр сарын 9-ний дугаартаа мэдээлснээс үзэхэд 1924 оны Бээжингийн хэлэлцээрийн 5 дугаар заалтыг үгүйсгэсэн нь илт байв. Харин 1924 оны хэлэлцээрийг Гадаад Хэргийн Ардын Комиссариатын «Олон улсын оны бичиг» сэтгүүлийн 1925 оны 5 дугаарт бас нийтлүүлжээ.<sup>15</sup>

Америкийн эрдэмтэн Жерард М. Фритерс «Гадаад Монгол ба түүний олон улсад эзлэх байр суурь» бүтээлдээ Зөвлөлт Орос 1924 онд Гадаад Монгол дахь Хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн нь Хятадын хувьд зарчимын ерөнхий санаа төдийгөөс өөр юу ч олоогүй юм гэж дүгнэж бичсэн<sup>16</sup> бол 1921-1945 онд БНМАУ Хятадаас хамааралгүй үндэсний улсын байдлаар хөгжиж байсан гэж ОХУ-ын доктор С.Г. Лузянин ч мөн дүгнэж бичжээ.<sup>17</sup>

1924 оны 5 дугаар сарын 31-ний Зөвлөлт-Хятадын хэлэлцээрийн 5 дугаар заалтын гол уршиг нь Монгол Улсын олон улсын эрхзүйн статусыг олон улсын

<sup>13</sup> Г.В.Чичерин. Статьи и речи по вопросам международной политики. М., 1961, с. 187-188

<sup>14</sup> Сборник действующих договоров, соглашений и конвенций, заключенных РСФСР с иностранными государствами. Выпуск 1, 1924 г. М., 1924

<sup>15</sup> Международная летопись. Выпуск 5. М., 1925

<sup>16</sup> Friters Gerard M. Outer Mongolia and Its International Position. L.: 1951, pp. 85-87

<sup>17</sup> Лузянин С.Г. Россия, Монголия и Китай в первой половине XX в. — М.: изд-во Института Дальнего Востока РАН, 2003.- Изд. 2-е, дополненное. стр. 110

тавцанд хоёрдмол ойлголттой болгоход хүргэж, энэ нь 1945 он хүртэл үргэлжилсэн явдал билээ.

Тиймээс ч Зөвлөлтийн удирдагч И.В.Сталин 1945 оны 6 дугаар сард Москвад эхэлсэн Зөвлөлт, Дундадын хэлэлцээний үеэр Ялтын хэлэлцээр манай хэлэлцээний үндэс болох ёстой. Рузвельт гарын үсгээ зурсан, Гадаад Монголын *status quo*-г хадгална гэдэг нь Хятадын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогнолыг хүлээн зөвшөөрнө гэсэн хэрэг хэмээн тайлбарлаж, хүлээн авахыг Хятадын төлөөлөгчдөөс шаардаж байсан ажгуу. Гадаад Монголыг тусгаар тогтноулахын утга учир нь ЗХУ-ын хувьд амин чухал ач холбогдолтой геополитик, аюулгүй байдлын асуудал, тиймээс уг хэлэлцээний үеэр энэ асуудлыг шийдвэрлэх ёстой, Гадаад Монголчууд Хятадтай ч тэр, ЗХУ-тай ч тэр нэгдэх хүсэлгүй, 25 жил Хятадаас хамааралгүй оршин тогтнож ирсэн, тиймээс тусгаар тогтнох хүсэлтэй байдаг, энэ нь Хятадын хувьд ч ашигтай, учир нь дотоод, гадаад монгол нэгдэх аюул буй гэж ятган тайлбарлаж, эцэстээ Монголыг буцааж өгнө гэж санах ч хэрэггүй гэсэн эцсийн хатуу байр сууриа илэрхийлж байсан юм.

МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны орлогч гишүүн, Сайд нарын Зөвлөлийн орлогч сайд ГЯЯ-ны сайд агсан С.Аварзэд ярилцлагадаа: 1957 онд В.М.Молотовтой ярилцаж байх үед тэрбээр “Ер нь ч ирээдүйд танай Монгол чинь хаана, ямар байх нь тодорхойгүй. Бас одоо хаана хүрч ирэх байсныг гэрчлэх түүхийн баримт бас бий. Танай Чойбалсан чинь Зөвлөлтөд дагаар орно гэж гурван удаа өргөдөл өгсөн юм шүү” гэж хэлсэн хэмээжээ. Энд тэрбээр дэндүү ташаарсан бололтой. 1939 онд Японы түрэмгийлэгчдийг Халхын голд бут цохих Монголын цэргийн үйл ажиллагааг биечлэн удирдаж ялалтад хүргэн, Монголын тусгаар тогнолыг Ялтын бага хурал дээр Америк, Англиар хүлээн зөвшөөрүүлэх талаар Сталинтай нягт хамтран ажиллаж, тэр ч байтугай бүх Монгол үндэстнийг чөлөөлж, нэгдүүлэн тусгаар тогтносон бүрэн эрхт, нэгдмэл эрх чөлөөт улс болгох бодлого баримталж, тусгаар тогтнолын асуудлаар бүх ард түмний санал асуулгыг 1945 онд чадамгай зохион байгуулж, улмаар Дундад улсаар хүлээн зөвшөөрүүлж, улс орноо НҮБ-д элсүүлэх талаар хатуу тууштай бодлого баримталж байсан энэ их хүн гэнэт бусад оронд дагаар орох санал ард түмнээсээ нууцаар олон удаа тавьж байсан гэдэгт үнэмшихэд тун хэцүү буйзаа.

1949 онд Х.Чойбалсан И.В.Сталинтай уулзах үеэрээ Ар, Өвөр Монголчуудыг нэгтгэх эрмэлзлэлтэйгээ мэдэгдэхийн хамт: “Хэрэв Гадаад ба Дотоод Монгол нэгдвэл яваандаа СССР-ийн холбооны улс болоход болох уу?” гэж асуусан нь тэмдэглэгдэн үлджээ. Энэ асуултад И.В.Сталин: “Танайх манай холбооны улс болох хэрэггүй. Бид Гадаад Монголыг дэмжихдээ Оросын харьяанд ч орохгүй, Хятадын харьяанд ч орохгүй, нэгдсэн нэгэн тусгаар улс байхыг хүсэж байна” гэж тов тодорхой хариулж байжээ. Маршал Х.Чойбалсангийн энэ асуултын талаар зарим судлаачид үзэхдээ тэрбээр ЗХУ-д нэгдэх бодол саналаа илэрхийлсэн гэж тайлбарлаж байхад, нөгөө хэсэг нь Өвөр Монголыг нэгтгэхдээ дэмжлэг авахын тулд ийнхүү асуусан байх магадлалтай гэж тайлбарласан нь буй.

Н.Лхамсүрэн “Хөдөлмөр” сонинд 1990 онд бичсэн ярилцлагадаа Д.Төмөр-Очир нарын зургаан хүний бичсэн ЗХУ-д нэгдэх тухай саналыг Х.Чойбалсан хүлээж аваад “Монголын сэхээтний сор гэгдсэн хүмүүс чинь бусад улсад дагаар оръё гэж бичсэн байна... Намайг амьд байсан цагт л ийм явдал болохгүй юм шүү дээ... Цэдэнбал ойр ойрхон орж ирж захидлын хариуг хурдан өгье гэж шалаад байх юм. Төмөр-Очир, Бадарч хоёрыг хурдан хүлээн авч уулзаач гэж ч хэлж байна. Би санааг нь ойлгоод байна. Ер нь Цэдэнбал Тувагийн Салчиг Тогоо шиг болох гээд л байнаа даа” гэж 40 гаруй жилийн өмнө өөрт нь ярьж байсан юм шигээр ерээд онд бичсэн нь буй.

БНМАУ-ыг ЗХУ-д нэгтгэх тухай санааг анхлан гаргаж зүтгэж байсан хүн нь Б.Жамбалдорж<sup>18</sup> байв. Ийм санаа бодол зарим хүмүүст хэдийд яагаад төрөв? гэдэг асуулт гарч байгаа юм.

Тэр үед энхтайвны төлөө тэмцлийн гол түшиг тулгуур нь ЗХУ болж байв. Зөвлөлтийн олон үндэстнүүдийн нөхөрлөл нь юунаас ч үнэтэй, бүхнээс хүчтэй юм гэсэн ойлголт Монголд төдийгүй дэлхийд нэн хүчтэй байсан зэрэг нь Зөвлөлтийг хүндэтгэн талархах, улмаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд орвол улс орноо илүү хурдацтай хөгжүүлж болох юм гэдэг төсөөллийг зарим хүмүүст төрүүлсэн байх магадлалтай.

КУТВ төгсч тухайн үед нам, төрийн өндөр хариуцлагатай алба хашиж явсан Б.Жамбалдорж 1944 оны 7 дугаар сарын 5-нд МАХН-ын ТХ-ны УТТ-нд хаяглан ирүүлсэн бичигтээ: “Монголын ард түмний ухамсартай хэсэг, МАХН-ын гишүүний хувиар... хэлэхэд манай Монгол Улс Зөвлөлтийн аугаа их гэр бүлд багтах нь манай улсын цаашдын түргэн хөгжилд их л утгатай бөгөөд цаг нь болсон асуудал гэж би бодно. Энэ санал бол гагцхүү над байгаа бус, олон хүмүүст байгаа юм” гэжээ. Одоогоор олдсон баримтаас харахад ЗХУ-д нэгдэх тухай асуудлыг хөндөж тавьсан анхны албан ёсны бичмэл баримт нь энэ болж байна.

Ю.Цэдэнбал дээрх асуудлыг зөв шийдэхэд ямар нэг хэмжээгээр оролцохоос өөр аргагүй байсан нь ойлгомжтой. Тэрбээр энэ асуудлыг тойруулж улс төрийн шуугиан дэгдээсэнгүй. Тийм зав ч байсангүй. Энэ саналыг тэр дэмжиж байсан буюу хатуу няцааж байсан баримт олдохгүй байгаагаас үзэхэд Монгол-Зөвлөлтийн найрамдлыг манай тусгаар тогтнолын нэг баталгаа гэж үзэж байсан түүхэн нөхцөлд улс төрийн залуу зүтгэлтэн тухайн саналд талтай байсан уу, цочирдсон уу, болгоомжилсон уу, ямар ч гэсэн маршал Чойбалсантай бүх асуудлыг байнга зөвлөж хариу өгч байжээ. Ю.Цэдэнбал уг бичгийг хүлээж аваад “Маршалд уламжлан илтгэв. (Сэргээн сануулав). Сталинтай ярилцаж заавар авахыг зөвлөв. Маршал уншаад зөвлөлгөө авна гэж хэлэв” гэж тэмдэглэж байжээ.

<sup>18</sup> Жамбалдорж, Бат-Очирын 1908 онд Дундговь аймагт төрсөн. 1936-1939 онд Москвад КУТВ төгссөн. 1934 оноос Өмнөговь аймгийн Намын хорооны дарга, 1939-1941 онд УАХГ-ын дарга, ДЯЯ-ны I дүгээр орлогч сайд, 1941-1946 онд Шүүх яамны сайд, 1947- 1953 онд Улсын Ерөнхий прокурор, 1947-1952 онд НТХ-ны УТТ-ны орлогч, 1952-1954 онд НТХ-ны УТТ-ны гишүүн, 1954-1958 онд НТХ-ны УТТ-ны орлогч, МАХН-ын ТХ-ны НХШХ-ны дарга, 1959-1960 онд ЗХУ-д элчин сайд, 1962 онд бүх албан тушаалаас нь огцруулсан. 1930-аад оны сүүлчээр эхэлсэн хэлмэгдүүлэлтэд голлох үүрэг гүйцэтгэсэн байна.

Түүний дараахан НТХ-ны нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав<sup>19</sup> болон АИХ-ын Тэргүүлэгчдийн орлогч дарга Д.Цэдэв<sup>20</sup> нар аанлай л иймэрхүү асуудал ярьж байсныг Зөвлөлтийн элчин И.А.Иванов<sup>21</sup> Москвад мэдээлж, ГЯЯ-наасаа “маш болгоомжтой байх, Монголын удирдлагын дээд явцуу хүрээлэлд ийм яриа гаргах шалтаг гаргахгүй байх” гэсэн чиглэл авч байжээ.

Х.Чойбалсан энэ саналын талаар ихээхэн уурсан хилэгнэж байсан тухай зарим хүмүүсийн дурдатгалд бичигдэж үлджээ. Элчин сайд Ю.К.Приходов<sup>22</sup> монголчуудын өмнөөс ЗХУ-д нэгдэх тухай захиа бичсэн үү? Дайны төгсгөл үе гэхэд Монгол нь нийгэм-эдийн засаг, соёлын хувьд хоцрогдсон орон хэвээр байв. Монголын хөгжлийг яаж хурдасгах вэ?, яаж өөд нь татах вэ? гэсэн асуулт монголчууд, түүний удирдагчдыг төдийгүй Монголд туслах халуун сэтгэл өвөрлөсөн зарим Зөвлөлтийн хүмүүсийн сэтгэлийг өвтгөж байсан цаг үе бөгөөд чухам ийм үед Монголыг ЗХУ-д нэгтгэх санаа бодол зарим монгол хүмүүс, түүнчлэн Оросын зарим дипломатч нарт төрсөн байхыг үгүйсгэх аргагүй. Чухам ийм байдлаар тэд монголчуудын бодол санааг өөрийнхөөрөө тааварлан Москвад бичиг цаасаар явуулсан байж болох талтай. Дээрх зургаан хүний бичгийн талаар Оросын судлаач Л.Шинкарев: “Бусад асуултыг ч мөн л яг ийм марксизм-ленинизмын талаарх Зөвлөлтийн нийтлэлийн хад чулуу шиг хатуу хүтүү үг өгүүлбэрээр найруулжээ. Бичвэрийг нь монгол хэлнээс орчуулсан орчуулга гэхээргүй бөгөөд орчуулга ч гэсэн тэмдэглэл алга. Захиаг Зөвлөлтийн ЭСЯ-нд бэлдсэн бөгөөд, намын мөлчийсөн хэвшмэл хэлцийг бусдаас илүү эзэмшсэн Приходов гар хүрсэн бололтой байдаг юм” гэсэн сонин санааг дэвшүүлсэн байдаг. Нэр бүхий зургаан хүний захидлын тухай Ю.К.Приходов Гадаад яамны 1 дүгээр орлогч сайд А.А.Громыкод 1950 оны 9 дүгээр сарын 13-ны албан бичгээр тодорхой мэдэгдэж байжээ.

<sup>19</sup> Сүрэнжав, Чимиддоржийн (1914-1991) 1936-1939 онд КУТВ, 1953-1956 онд ЗХУКН-ын дээд сургуульд суралцсан. 1940 оноос МАХН-ын дэргэдэх Намын дээд сургуулийн ректор, НТХ-ны хэлтсийн эрхлэгч, НТХ-ны УТТ-ны гишүүн, Ерөнхий сайдын 1 дүгээр орлогч дарга, НТХ-ны 2 дугаар нарийн бичгийн дарга, АИХ-ын даргаар ажиллаж байв. 1959 онд бүх албан тушаалаасаа чөлөөлөгдсөн.

<sup>20</sup> Цэдэв, Дожоогийн 1913 онд Говь-Алтай аймгийн Тайшир суманд төрсөн. 1929-1932 онд Эрхүү хотод Монгол рабфак, 1940-1944 онд Эрхүүгийн Багшийн дээд сургуульд суралцан түүхийн багш мэргэжил эзэмшжээ. 1932-1940 онд багш, хичээлийн эрхлэгч, захирал, 1944-1946 онд Засгийн газарт референт, 1946-1949 онд ДЯЯ-ны сайдаар ажиллаж байв. 1949-1956 онд УБХ-ын Тэргүүлэгчдийн орлогч дарга, 1956-1959 онд Москвад ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх НУА-ийн аспирантурт суралцан түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. 1959-1968 онд Намын түүхийн институтэд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Түүхийн хүрээлэнд секторын эрхлэгч болон дипломат албанд ажиллажээ. СнЗ-ийн хурлын 1946 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор хошууч генерал цол хүртэжээ. 1968 онд “Монгол-Зөвлөлтийн найрамдал ба МАХН” нэг сэдэвт бүтээл тууривжээ.

<sup>21</sup> Иванов, Иван Алексеевич (1906-1948) 1939-1941 онд ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Бүрэн эрх барих элчин төлөөлөгч, 1941-1947 онд Онц бөгөөд Бүрэн эрхт элчингээр ажиллаж байв. Хошууч генерал цолтой. 1948 оноос ЗСБНХАУ-аас Афганистанд суугаа элчин сайдаар ажиллаж байгаад учир битүүлэг амь үрэгдсэн.

<sup>22</sup> Приходов, Юрий Кондратьевич (1906-1989) ДЯЯ-ны ажилтан, зөвлөлтийн дипломатч, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цолтой. 1940-1946 онд БНМАУ дахь ЗХУ-ын Элчин төлөөлөгчийн газрын зөвлөх, 1947-48 онд ЗХУ-ын ГЯЯ-ны Зүүн Өмнөд Азийн хэлтсийн эрхлэгч, 1948-1950 онд ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа элчин төлөөлөгч, 1950-1951 онд ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, 1951-1952 онд ЗХУ-ын ГЯЯ-ны Боловсон хүчний удирдах газрын орлогч дарга, 1952-1954 онд ГЯЯ-ны Коллегийн гишүүн, Боловсон хүчний удирдах газрын дарга, 1954-1960 онд БНБАУ-д суугаа элчин сайд, 1960-1961 онд ГЯЯ-нд ажилтан, 1961-1977 онд ЗСБНХУ-ын Бүх Холбоотны Худалдааны танхимийн (1972 оноос Худалдаа, аж үйлдвэрийн танхим болсон) Тэргүүлэгчдийн 1 дүгээр орлогч даргаар ажиллаж байжээ.



Ю.Цэдэнбалын хамтран зүтгэгч, хожим нь хохирч явсан С.Жалан-Аажав дурсахдаа: “Ю.Цэдэнбал Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх талаар үлэмж их зүйлийг хийж бүтээсэн жинхэнэ эх оронч хүн байсан юм. Ю.Цэдэнбалыг Оросын талыг баримтлагч, оросын сонирхол, ашиг тусын төлөө ажиллаж байсан гэж зарим хүмүүсийн ямар ч баримт нотолгоогүй ярьдагтай би огтхон ч санал нийлдэггүй. Ю.Цэдэнбал Монгол Улсын тусгаар тогтнолыг тууштай хамгаалж байсан тухай би энд баримт хэлэхийг хүсэж байна. Л.Цэнд, Д.Төмөр-Очир нар тэргүүтэй манай хэсэг сэхээтэн Сонгины амралтын дэргэд тусгай гэр бариулан тэнд байрлаж, 7 хоног ажиллаж, Монгол Улсыг түргэн хөгжүүлэхийн тулд ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулж холбооны улс болгох тухай санал тавьсан баримт бичиг боловсруулаад түүнийгээ маршал Х.Чойбалсанд гардуулахыг хүсэж Ю.Цэдэнбалд өгсөн байдаг юм. Гэтэл Ю.Цэдэнбал тэр баримт бичгийг хүлээж авсан боловч ...тэр тухай маршалаас өөр хэнд ч, юу ч ярилгүйгээр төмөр шүүгээндээ хийгээд өнгөрүүлж байсан тухайгаа өөрөө нэг бус удаа, бүр сүүлд бидэнд хууч болгон ярьдаг байсан” гэжээ. Үнэхээр ч энэ захидлын тухай ямар ч хурал дээр яриагүй, ямар ч хэвлэлд нийтлээгүй, Ю.Цэдэнбал энэ бичгийн талаар олон арван жил ганц ч үг яриагүй өнгөрсөн нь сонирхол татаж байгаа юм.

Намын Хянан Шалгах Хорооны дарга агсан Т.Гэндэн бичихдээ: “Тэр үед хэсэг нөхдүүд Оростой нэгдэх гэсэн санал гаргаж байсан. Нэр ус нь тодорхой. Жишээ нь: НТХ-ны УТТ-ны гишүүн Жамбалдорж энэ саналыг Зөвлөлтөд тавьсан боловч Зөвлөлтийн тал хүлээж аваагүй. Төмөр-Очир, Цэнд нарын захиа, энэ тэр гээд Оростой нийлье гэж санал тавьж байсан боловч Монголын дээд удирдлага, тухайлбал Чойбалсан, Цэдэнбал нар дэмжээгүй” гэжээ.

Д.Дамбын дурссанаар дээрх НТХ-ны Улс Төрийн товчооны хурлын дараахан ЗХУ руу И.В.Сталиныг оршуулах ёслолд оролцохоор явах үед Ерөнхий сайд Ю.Цэдэнбал Намын Төв Хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга Д.Дамбад: “Дээрх асуудлаа тэгсхийгээд зогсооно байгаа. Тэр тогтоолыг гаргуулахгүй байх нь зүйтэй” гэсэн хариуцлагатай үүрэг өгөөд явсан нь түүхийн үнэ цэнэтэй баримт болон үлджээ. Энэ тухай ЗХУ-ын ГЯЯ-ны орлогч сайд (Ази-Номхон далай, түүний дотор Монголыг хариуцсан) байсан, олон улсын харилцааны түүхч, дипломатч, академич М.С.Капица<sup>23</sup> “Дипломатчийн тэмдэглэл” дурсамж номондоо: “1953 оны 3 дугаар сард болсон МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны хурал БНМАУ-ыг ЗХУ-д нэгтгэх үзэл санаа бүхий тогтоол гаргахыг дэмжиж байсан юм. Гэтэл Ю.Цэдэнбал Москва руу нисэхийнхээ өмнөхөн ийм тогтоол гаргаж болохгүй тухай шийдвэр өгсөн” гэж нотлон бичсэн нь судалгааны төдийгүй улс төрийн ач холбогдолтой байж болох юм.

Мэдээжийн хэрэг Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны сайд В.М.Молотовтой<sup>24</sup> уулзахад

<sup>23</sup> М.С.Капица. На разных параллелях. Записки дипломата. М., 1996. стр. 112

<sup>24</sup> Молотов, Вячеслав Михайлович (1890-1986) 1920-1921 онд Украины К(б)Н-ын ТХ-ны нарийн бичгийн дарга, 1921-1922 онд Бүх Оросын К(б)Н-ын хариуцлагатай нарийн бичгийн дарга, 1930-1941 онд ЗХУ-ын Ардын комиссаруудын Зөвлөлийн дарга, 1939-1946 онд Гадаад Хэргийн Ардын Комиссар, 1946-1949 онд ГХЯ-ны сайд, 1953-1956 онд ГЯЯ-ны сайд, СнЗ-ийн 1 дүгээр орлогч, 1956-1957 онд Хянан шалгах яамны

энэ тухай асуудал хөндөгдсөн бөгөөд Монголыг ЗХУ-д нэгтгэхийг санаачлагч нь хэн юм бэ? гэхэд “прокурор” гэж хариулж байснаа, ЗХУ-д нэгдэх тухай Монголчуудын зарим хэсгийн тэр үеийн туйлшралын шуургыг аянд нь эвтэйхэн намжаан дарахад Монголын тусгаар тогтнолыг гүн хүндэтгэх Зөвлөлтийн бодлого ихээхэн тус дэм болсныг гэрчлэх дээрх ярианы тэмдэглэлийг хожим хойно хэрэг болно гэж үзсэн байх, Ю.Цэдэнбал маш тодорхой нэгд нэгэнгүй бичиж үлдээсэн нь хойшдын ажилд нь нэлээн тус болсон, зоригжуулсан төдийгүй түүхийн үнэт баримт болжээ.

Энэхүү тэмдэглэлд Ю.Цэдэнбал бичихдээ: “В.М.Молотов хүлээн авч уулзсан юм. Бид 1953 оны 3 дугаар сарын 8-нд Москвад нисэж ирлээ. Сталины шарилд цэцэг өргөсний дараа би элчин сайд Н.Ядамжавын хамт 23:00 цагт ГЯЯ-ны 1 дүгээр орлогч сайд нөхөр Я.А.Маликтай уулзаж ЗСБНХУ-ын Засгийн газар, Зөвлөлтийн ард түмэнд Монголын ард түмэн, Монголын Засгийн газар, МАХН-ын нэрийн өмнөөс болон хувиасаа гүн эмгэнэл илэрхийлэв... В.М.Молотов таныг хүлээж авах бодолтой байгаа гэж тэр хэлэв... 3 дугаар сарын 21-нд Молотов над руу утасдаж, энэ хугацаанд таныг хүлээж авч амжсангүй. Тантай ярих олон асуудал байна. Даваа гаригт 2 цагаас хойш уулзъя гэв. 3 дугаар сарын 23-нд ГЯЯ-нд В.Молотов ганцаараа хүлээж авлаа. Тэр хэлэхдээ энэ бол А.Я.Вышинскийн ажлын өрөө байгаа юм. Ямар ч тоног төхөөрөмж байхгүй. Би энд анхны өдрөө байгаа нь энэ. Оршуулгын үеэр зүгээр л үзэх гэж нэг орж ирж байсан юм. ЗСБНХУ-д нэгдэх гэсэн асуудлын тань талаар тантай ярихыг над даалгасан юм. Танай энэ шийдвэр бол бүдүүлэг алдаа юм. Одоо бол цаг нь биш ээ. Олон улсын байдлыг та нар мэдэж байгаа шүү дээ. Зөвлөлтийн империализмын тухай дахиад л ярьцгаах болно. Энэ шийдвэрээ цуцлах хэрэгтэй. Энэ явдал танай НТХ-ны нэр хүндийн хувьд эвгүй л юм болно. Гэхдээ яахав, цуцлах л болж дээ. Танай энэ шийдвэрээс чинь болчимгүй зан ханхалж байна. Анхнаасаа зөвлөж ярих хэрэгтэй байсан шүү дээ. Цэдэнбал миний хэлсэн нь: Шийдвэрээ цуцалъя аа гэв. Би ярихдаа УТТ-ны зарим гишүүд энэ асуудлыг НТХ-ны бүгд хурал, АИХ-ын чуулганд оруулахыг шаардсан юм. Дараа нь олон улсын байдал төвөгтэй, хурцадмал байгаа тухай, энд бидний мэдэхгүй байгаа зүйлийг мэдэж байгаа учраас ЗХУКН-ын ТХ-нд хандах тухай ярьцгаасан юм гэв. В.Молотов “Ер нь танайд нэг нь нөгөөгөөсөө илүү зүүн тийш хэлбийх юм. Бидэнд нуугаад байх юм байхгүй ээ. Манай бодлогыг та нар мэдэж байгаа. Манай бодлого дэлхий дахинд илэрхий. Харин асуудал бэлтгэгдэж, хэлэлцэгдэж байгаа үедээ нууц байх тал бий. Олон улсын байдал цаашдаа ч хурцадмал хэвээр байх болно. Түр зуур жаахан намжааж болох байх. Сталин юуг яах гэж бодож байсныг бид мэдэхгүй. Бид хамтран урьдаас илүү сайн ажиллах хэрэгтэй. Урьд гарсан олон шийдвэрийг эргэж харах болж байна гэв. 1953 оны 3 дугаар сарын 25-нд В.М.Молотов: намайг ГЯЯ-ндаа хүлээж авлаа. Энэ уулзалт дээр элчин сайд Г.И.Иванников<sup>25</sup> байлцсан...”

сайд, 1957-1960 онд ЗХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, 1960-1961 онд Вена хотноо НҮБ-ын Олон улсын атомын эрчим хүчний агентлагт суугаа байнгын төлөөлөгчөөр ажиллажээ.

<sup>25</sup> Иванников, Георгий Иванович (1908-?) 1951-1953 онд ЗХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байсан. БХК(б)Н-ын гишүүн. 1929-1936 онд Аж үйлдвэрийн академи төгссөн. 1943 он хүртэл Зөвлөлт Туркменистаны СнЗ-ийн орлогч дарга, 1943-1946 онд Ашхабадын намын хорооны

В.Молотов: Монголыг зөвлөлтөд нэгтгэхийг санаачлагч нь хэн юм бэ? -Цэдэнбал: прокурор! -В.Молотов: Юутай ч гэсэн улс төрийн бодлоготны хувьд тааруухан хүн юм даа. Та нар жаахан автагдсан байна. Би таныг хүлээж авалгүй жаахан удчихсан. Манайд томоохон өөрчлөн байгуулалт явж байна. Гэхдээ та бол өөрийн хүн шүү дээ. Та үүнийг ойлгож байгаа” гэж байжээ.<sup>26</sup>

“БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах тухай санал” хэмээх томоохон хоёр баримт бичгийн жинхэнэ гардан зохиогчид Д.Төмөр-Очир, Л.Цэнд, Ц.Дүгэрсүрэн, Б.Бадарч, С.Авирмэд, Г.Галбадрах нарт Монгол Улсаа яаж хурдан хөгжүүлэх вэ гэсэн бодол санаа мэдээж байсныг тэмдэглэхийн хамт гол нь тэдний боловсруулсан баримт бичгүүдэд **өөрийн ард түмний тусгаар тогтнолоо хамгаалж ирсэн түүхэн үнэ цэнэ, тусгаар тогтнолын төлөөх бүх ард түмний санал хураалтын үр дүнг үгүйсгэж, монголын ард түмний хүч бололцоог хэт дутуу үнэлсэн, нигилист хандлага нэвт шингэсэн байсныг онцлон тэмдэглэх ёстой. Чухам иймэрхүү үгүйсгэх үзлийнхээ улмаас эдгээр зохиогчдын зарим нь хожим намаасаа ноцтой зэмлэл хүртэж байсан юм.**

Дээрх хоёр баримт бичгүүд нь маш ноцтой байсан бөгөөд удирдах хүрээллийн дунд тодорхой эргэлзээ сэдэл буй болгож, тиймээс тэрхүү үйлдлийг намжаах нэн хариуцлагатай үүрэг Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарт ногдож, тэд ч асуудлыг томоохон дуулиан шуугиан болгожгүй өнгөрүүлж чаджээ.

Дээрх баримт бол монголын түүхийн том сургамж болой.

## ДҮГНЭЛТ

2019 оны 11 дүгээр сарын 26-нд Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улс тунхагласны 95 жилийн ойн өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ёсчилж баталж, 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 цагаас буюу XVII жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн 3-ны рашаан барилдлагатай өлзийт сайн шар луу өдрийн морин цагаас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэв.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад “Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно” гэсэн цоо шинэ заалт орсон нь зарчмын нэн чухал ач холбогдолтой болсон гэдгийг онцлон тэмдэглэх ёстой.

2014 оны хавар Украины нутаг дэвсгэр Крымын хойгийг ОХУ-д нэгтгэсэн үйл явц олон улсын харилцаа, геополитикийн түүхийн том сургамж болсон билээ.

---

1 дүгээр нарийн бичгийн дарга, 1949-1951 онд БНМАУ-д суугаа ЗХУ-ын ЭСЯ-нд зөвлөх, 1951-1953 онд ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, 1959 оноос Зөвлөлт Туркменистаны Худалдаа-санхүүгийн Засаг захиргааны хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байжээ.

<sup>26</sup> Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. (Эмхтгэсэн Б.Сумьяа) УБ., 1992

## НОМ ЗҮЙ

- “БНМАУ-ын ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудал тавьсан нь.” Үнэн сонин, №178, 1990.
- “БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах асуудлыг дахин тавьсан нь” Үнэн сонин, №185, 1990.
- МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлын сонгол мэдээ. “Б.Сумьяа. Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд өгөх улс төрийн дүгнэлт”. Үнэн сонин, №155, 1990 (17685)
- МАХН-ын XVII их хурал, дэлгэрэнгүй тайлан. УБ, 1976.
- Капица М.С. “На разных параллелях.” Записки дипломата. М., с. 97, 1966
- Надилов Ш.Г. “Цеденбал 1984 год.” Издательский дом. М., 1995.
- Надилов Ш.Г. “Вассал или союзник Кремля” // Азия и Африка сегодня. - № 5. - с. 32-39, 1995.
- Надилов Ш.Г.” Цеденбал как политик и его роль в развитии советско-монгольских отношений” Россия и Монголия: новый взгляд на историю взаимоотношений в XX веке: сб. статей. М.: Институт Востоковедения РАН, М., с. 184-200, 2001.
- Шинкарев Леонид. И. Цеденбал и Филатова: Любовь. Власть. Трагедия. Издатель Сапронов. М., 2004.
- Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. (Эмхтгэсэн Сумьяа.Б) УБ., 1992.
- Гүрбадам. Ц, Цэдэнбал.Ю: Түүхэн үнэний тухай бодрол. Элчин сайдын дурсамж. УБ., 1994.
- Жамбалсүрэн. Ц, Монголыг ЗХУ-д нэгтгэх саналыг хэн гаргаж байсан бэ? УБ., 2006.
- Жамбалсүрэн. Ц, Цэдэнбал.Ю.: Эрин зууны түүхэн элч. УБ., 2007.
- Уламбаяр. Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. XX зууны тэргүүн хагаст. Тэргүүн боть. УБ., 2013.
- Уламбаяр.Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, дипломат ажиллагаа, аюулгүй байдал. XX зууны сүүлийн хагаст. Дэд боть. УБ., 2020.